



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/964

Арвайхээр

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай**


Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэр бүхий газар эзэмшигчдийн гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт байрлах 8 нэгж талбарын газар эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн эзэмшил газрыг зориулалтын дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг тус тус шилжүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2007 оны 95 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх хэсгийн Өвөрхангай аймгийн шүүх, прокурорын газартай холбогдох заалт, 9 дэх хэсгийн Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, Хөдөө аж ахуйн газартай холбогдох заалт, 2008 оны 168 дугаар захирамж, 2016 оны а/311 дүгээр захирамжийн хавсралтын Өвөрхангай аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэстэй холбогдох заалт, 2015 оны а/140 дүгээр захирамжийн Өвөрхангай аймгийн Ахмадын хороотой холбогдох заалт, 2016 оны а/39 дүгээр захирамжийн Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газартай холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101660

D:My Doc. Zahiramj. Zasag darga



Аймгийн Засаг даргын 2018 оны 12
дугаар сарын 14-ны өдрийн 164 дугаар
захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД
ШИЛЖҮҮЛЭХ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Газар эзэмшигчийн овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ /м ²	Газар эзэмших эрх шилжүүлэн авагчийн овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Эрх шилжүүлэн эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ /м ²	Газрын байршилын нэр, хаяг	Эзэмших хугацаа
1.	Өвөрхангай аймгийн Шүүх, прокурор	9044663	Төрийн захиргааны байгууллага	1835	Өвөрхангай аймгийн Шүүхийн тамгийн газар	9044663	Төрийн захиргааны байгууллага	1160	13-р баг, Гэндэн-3-р гудамж, 302 тоот	28 жил 8 сар
2.					Өвөрхангай аймгийн прокурорын газар	9044671	Төрийн захиргааны байгууллага	675	13-р баг, Гэндэн-3-р гудамж, 302а тоот	28 жил 8 сар
3.	Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, Хөдөө аж ахуйн газар	9044264	Мал Эмнэлэг	5854	Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн Өвөрхангай аймаг дахь салбар	2688417	Дэд станц	100	10-р баг, Ноёны гудамж, 393а тоот	49 жил 9 сар
4.					Өвөрхангай аймгийн Мал эмнэлэгийн газар	3565351	Мал Эмнэлэг	5754	10-р баг, Ноёны гудамж, 393 тоот	49 жил 9 сар